



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 1/303

Улаанбаатар хот

Г

Т

Журам батлах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр баталсан "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-ний 4.1.2, 4.1.25 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 6.12 дахь заалт, тус үйлдвэрийн газрын 2018 оны А/25 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.4, 4.1.11, 4.4 дэх заалтууд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан 05/29 тоот гэрээний 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Автотээврийн үндэсний төвийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Автотээврийн үндэсний төвийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам"-ыг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Автотээврийн үндэсний төвийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг үйлдвэрийн газрын нийт ажилтнуудад танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Б.Мөнхгарьд/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

П.ДЭЛГЭРНАРАН





БАРИМТЖУУЛСАН ЖУРАМ
ЗСХНХ 08-10-2018

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирлын
2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн

1303 дугаар тушаалын хавсралт

УХЛ0190 5324165

**"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН АЖИЛТНЫ
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Боловсруулсан:	Хянасан:
 Л.Батдэлгэр	 А.Дамбадаваа

ЭХ ХУВЬ

МӨРДӨЖ ЭХЭЛСЭН ОГНОО: 2018.10.08
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО:
ӨӨРЧЛӨЛТИЙН № 00

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

ӨӨРЧЛӨЛТИЙН № 00**ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ**

Д/д	Өөрчлөлт №	Хуудас №	Өөрчлөлтийн утга

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

АГУУЛГА

Д/д	Бүлэг	Хуудас №
1	Өөрчлөлтийн бүртгэл	2
2	Агуулга	3
3	Нийтлэг үндэслэл	4
4	Ажилтныг байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах, байр, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх	5
5	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх	6
6	Ажилтныг сурч боловсрох чиглэлээр дэмжлэг үзүүлэх	6
7	Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх	7
8	Бусад	8

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрийн газрын "Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-т ажилтнуудыг үе шаттай хамруулах, чадварлаг ажилтнуудыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, ажлын үр бүтээлийг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. "Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" болон "Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр"-ийн хүрээнд ажилтанд байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах, эрүүл мэнд, сургалтын чиглэлээр дэмжлэг үзүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.3. Энэхүү журмыг холбогдох хууль тогтоомж, үйлдвэрийн газрын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмуудтай уялдуулан ил тод нээлттэй хэрэгжүүлнэ.

1.4. Үйлдвэрийн газарт түр томилогдсон, хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудад энэхүү журам хамаарахгүй.

1.5. Ажилтны нийгмийн баталгааг хангах болон ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөрт хамрагдсан ажилтанг З жилийн хугацаанд эдгээр хөтөлбөрт дахин хамруулахгүй ба зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж болно.

1.6. Үйлдвэрийн газрын "Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүрийн зорилтот түвшинд тусгасан зардлыг энэхүү журамд заасны дагуу зарцуулна.

1.7. Нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх хүрээнд тухайн жилийн зорилтод түвшинд батлагдсан зардлаас олгогдох мөнгөн дүн, хамрагдах хүрээг Захирлын зөвлөлийн хуралдаанаар тогтооно.

Хоёр. Ажилтныг байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах, байр, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх

2.1. Ажилтнуудын байр, орон сууцны судалгааг жил бүр гаргаж, тухайн судалгаанд үндэслэн байр, орон сууцны нөхцөлөө сайжруулахад тухайн жилийн батлагдсан эх үүсвэрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

2.2. Ажилтнуудыг зуслангийн нэг загварын байр барих, өмчилж авахад нь үйлдвэрийн газрын зүгээс дэмжлэг үзүүлж болно.

2.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (гал, үер, газар хөдлөлт болон бусад давагдашгүй хүчин зүйлс)-ийн улмаас орон гэрт нь хохирол учирсан ажилтанд тусламж үзүүлнэ.

2.4. Ажилтан амьдрах байр, орон сууцны нөхцөлөө сайжруулахад дараах төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Үүнд:

2.4.1. Байр, орон сууц анх удаа худалдан авахад урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх;

2.4.2. Өөрийн өмчлөлийн хашаа байшин, орон сууцгүй ажилтанд орон байр худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх;

2.4.3. Гэрт амьдарч буй ажилтан амьдрах нөхцөлөө сайжруулж байшин барихад нь дэмжлэг үзүүлэх;

2.4.4. Анх удаа хашаа байшин худалдан авахад дэмжлэг үзүүлэх;

2.4.5. Байр, орон сууцны нөхцөлөө сайжруулахаар банкнаас авсан зээлийн эргэн төлөлтөд дэмжлэг үзүүлэх.

2.5. Байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах санхүүгийн дэмжлэгийг ажилтанд үйлдвэрийн газарт ажиллах хугацаанд 1 /Нэг/ удаа олгох бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

2.5.1. Тухайн үйлдвэрийн газарт 5 /Тав/-аас доошгүй жил тогтвортой суурьшилтай ажилласан байх;

2.5.2. Үр бүтээлтэй ажилласан байх буюу ажлын үр дүн нь “В” буюу түүнээс дээш үнэлгээтэй дүгнэгдсэн байх;

2.5.3. Сахилгын шийтгэлгүй байх;

2.5.4. Байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах дэмжлэг авах зайлшгүй шаардлага байгаа талаар үнэн зөв тодорхойлолт, тайлбар, нотлох баримттай байх;

2.6. Байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд дараах шаардлагуудыг харгалзан үзнэ. Үүнд:

2.6.1. Залуу гэр бүл;

2.6.2. Өрх толгойлсон эх /эцэг/.

Гурав. Ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх

3.1. Ажилтан хүнд өвчний улмаас эмчлүүлж байгаа, мөн гадаад улсад эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн газрын зүгээс дэмжлэг тусламж үзүүлж болно.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

3.2. Гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт" болон холбогдох эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэнэ.

Дөрөв. Ажилтныг сурч боловсрох чиглэлээр дэмжлэг үзүүлэх

4.1. Үйлдвэрийн газраас ажлын байрны шаардлагын дагуу захиалгаар дараах сургалтуудад хамрагдах тохиолдолд дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

4.1.1. Гадаад оронд урт болон богино хугацааны сургалт;

4.1.2. Ажиллахын зэрэгцээ дотоодын урт болон богино хэмжээний сургалт.

4.2. Энэхүү журмын 4.1-т заасан сургалтын дэмжлэг авах ажилтан дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

4.2.1. Тухайн үйлдвэрийн газарт 3 /Гурав/-аас доошгүй жил тогтвортой суурьшилтай ажилласан байх;

4.2.2. Үр бүтээлтэй ажилласан байх буюу ажлын үр дүн нь "В" буюу түүнээс дээш үнэлгээтэй дүгнэгдсэн байх;

4.2.3. Сахилгын шийтгэлгүй байх;

4.2.4. Энэхүү журмын 4.1-т заасан сургалтад үйлдвэрийн газрын зардлаар суралцаагүй байх.

4.3 Гадаад орон болон дотоодод нэн хэрэгцээтэй мэргэжлээр, захиалгаар суралцах төлбөрт 100 хүртэл хувийн дэмжлэг үзүүлж болно.

4.4. Үйлдвэрийн газраас ажлын байрны шаардлагын дагуу захиалгаар гадаад орон болон дотоодод нэн хэрэгцээтэй мэргэжлээр, хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлбөрийн дэмжлэг авсан тохиолдолд үйлдвэрийн газарт 3 /Гурав/-аас доошгүй жил үр бүтээл, тогтвортой суурьшилтай ажиллана.

Тав. Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх

5.1. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын нэгжүүд энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан ажилтандаа дэмжлэг үзүүлэх талаар хамт олны хурлаар хэлэлцэн, нэгдмэл саналтай байгаагаа хурлын тэмдэглэлээр тодорхойлно.

5.2. Хамт олны хурлын шийдвэрээр энэхүү журамд заасан дэмжлэг авахаар тодорхойлогдсон ажилтан өргөдөл гаргаж, холбогдох материалыг бүрдүүлэн үйлдвэрийн газрын Захиргаанд хүргүүлнэ.

5.3. Үйлдвэрийн газрын Захиргаа нь энэхүү журамд заасан дэмжлэг авахаар ирүүлсэн материалыг судлан үзэж, хамт олны хурлын тэмдэглэлийг үндэслэн захирлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж зохих шийдвэрийг гаргана.

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖКҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8

5.4. Үйлдвэрийн газрын Захиргаа шаардлагатай тохиолдолд баримт материалыг тодруулах, нэмэлт материал ирүүлэхийг тухайн ажилтнаас шаардаж болно.

5.5 Захирлын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн үйлдвэрийн газрын захирлын тушаалаар ажилтнуудад зохих дэмжлэгийг үзүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, журмын дагуу захирлын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү журмын хэрэгжилтэд үйлдвэрийн газрын ажилтнууд хяналт тавих бөгөөд Хяналт, шинжилгээ, дотоод аудитын алба жилийн эцэст журмын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж захирлын зөвлөлд танилцуулна.

6.3. Журмын хэрэгжилтийн талаар үйлдвэрийн газрын удирдлага, ажилтнууд тодорхой санал, хүсэлт гаргаж болох бөгөөд журмын хэрэгжилтийн явц, үр дүн, ажилтнуудын санал хүсэлтийг үндэслэн журамд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.4. Журамд нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүрт үйлдвэрийн газрын Захиргаа нийт ажилтнуудад танилцуулж, ил тод байдлыг хангаж ажиллана.

--- оОо ---

Баримт бичгийн № ЗСХНХ 08-10-2018	АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	
Хэвлэсэн огноо: 2018.10.08	Өөрчлөлт № 00 Өөрчлөлтийн огноо:	Хуудас № 1/8